

Golomt Capital®

# БОНДЫН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.07.30



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.95%
Монгол 27	2027.07.07	3.50%	6.30%
Хүннү	2028.01.19	8.65%	6.09%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.21%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.61%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.84%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.95%-6.84% хооронд хэлбэлзэж байна.



## КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.90%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.73%
TDBM	2027.12.23	8.5%	9.65%
DBM	2026.03.07	11.00%	6.87%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.87%-12.73%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Golomt Capital®

2021-2024 он

19%

дундаж хүү

Нийт

3.000

хөрөнгө оруулагч

Нэг хөрөнгө оруулагч

95сая₮

хүртсэн өгөөж

Одоо  
₮20%БОНД АВАХ  
₮10сая

ЖИШЭЭ

ХҮРТЭХ  
₮2сая  
ӨГӨӨЖ

## \$ АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

### Ам.доллар үргэлжлэн суларсаар байна

Долларын эсрэг байр суурь яагаад давамгайлж эхлэв?

Холбооны Нөөцийн бодлого зөөлрөх төлөвтэй – 2025 оны 3-р улирлаас эхлэн АНУ-ын төв банк бодлогын хүүгээ бууруулж магадгүй гэсэн хүлээлт нэмэгдэж байгаа нь долларын ханшид сөргөөр нөлөөлнө гэсэн хүлээлтийг бий болгож байна.

АНУ-ын төсвийн алдагдлын өсөлт – “One Big Beautiful Bill” гэх шинэ төсвийн бодлого нь АНУ-ын өрийг огцом нэмэгдүүлж, ам.долларын нэр хүндийг бууруулах эрсдэл үүсгэж байна. Олон улсын төв банкууд алт болон бусад валют руу хөрөнгөө шилжүүлж буй – Энэ нь долларын нөөц валютын байр сууринд ан цав үүсч болзошгүйг илтгэж байна. Түүхэндээ анх удаа “Short US dollar” буюу долларын уналтад тоглолт хийж буй хөрөнгө оруулалт хамгийн түгээмэл, хамгийн эрсдэл өндөр төвлөрөлтэй арилжаа болжээ.

График 2. АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж



Трамп бодлогын хүүг яаралтай бууруулахыг шаардаж байгаа бол, Пауэлл инфляц, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан түр хүлээх нь зүйтэй гэж үзэж байна. 7-р сарын 30 шөнө ХНС-н ээлжит хурал болох бөгөөд бодлогын хүүгийн талаарх шийдвэрийг танилцуулж зах зээлд өндөр савлагаа үүснэ.

АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж 4.36% хүртэл буурлаа. Энэ нь хөрөнгө оруулагчид АНУ-ын өрийн бодлого болон ерөнхий макро эдийн засгийн тодорхойгүй байдал дээр анхаарлаа хандуулж буйн илрэл юм.

ЗГ-ын бондын анхдагч дилерүүдийн үзэж буйгаар, 2025 оны 3-р улиралд АНУ бондын дуудлага худалдааны хэмжээг нэмэгдүүлэхгүй байх магадлалтай байна. Энэ нь өрийн хязгаарын асуудалтай холбоотой улс төрийн тогтворгүй байдал, мөн Ерөнхийлөгч Трампын баталсан тэлэлтийн шинжтэй төсвийн шинэ хуулийн нөлөөлөл зэргийг харгалзан үзсэн шийдвэр юм.

## ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ 34.6 их наядад хүрсэн

2025 оны I улирлын байдлаар Монгол Улсын Засгийн газрын өр 34.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3%-иар өссөн байна. Энэ өсөлтөд гадаад зээл, ялангуяа Азийн Хөгжлийн Банкнаас авсан их хэмжээний зээл, нүүрсний экспортын орлого багассантай холбоотой төсвийн нөхцөл хүндрэл зэрэг нь голлон нөлөөлжээ. Мөн 2024 оны I улирлаас хойш эдийн засгийн өсөлт удааширсан ч Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь улам өссөөр байгаа нь өрийн тогтвортой байдалд сөрөг дохио болж байна. Тухайлбал, 2025 оны эхний улиралд эдийн засаг 2.4%-иар өссөн ч, өрийн ДНБ-д эзлэх хувь 1.7 пунктээр нэмэгджээ.


Эх сурвалж: Bloomberg

### Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ТУСГАЙ САНАЛ 30%

8083-6622 | 8888-9183 | 8665-4422 | 8083-9944